

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГУУДАД ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН  
/2023.01.01-2023.12.25/**

2023 оны 12 дугаар сарын 25 өдөр


Улаанбаатар хот

**Нэг.** Иргэдээс Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Харьяа 25 Эрүүл мэндийн байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын нийт тоо **4833** байна.

№	Эмнэлгийн нэр	Нийт ирсэн өргөдөл	Шийдвэрлэсэн хувь
1	Хан-Уул Эрүүл мэндийн төв	384	99%
2	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	279	98%
3	Баянзүрх Эрүүл мэндийн төв	692	99%
4	Баянгол Эрүүл мэндийн төв	5	99%
5	Багануур Эрүүл мэндийн төв	95	100%
6	Багахангай Эрүүл мэндийн төв	5	100%
7	Налайх Эрүүл мэндийн төв	96	100%
8	Сүхбаатар Эрүүл мэндийн төв	434	98%
9	Сүхбаатар нэгдсэн эмнэлэг	136	99%
10	Сонгинохайрхан Эрүүл мэндийн төв	547	98%
11	Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг	393	99%
12	Чингэлтэй Эрүүл мэндийн төв	258	98%
13	Нийслэлийн Түргэн тусламжийн төв-103	799	98%
14	Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв	54	100%
15	Энэрэл эмнэлэг	22	94%
16	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг	78	100%
17	Сэргээн засах клиник эмнэлэг	21	100%
18	Гачуурт Эрүүл мэндийн төв	6	100%
19	Аддиктологийн төв	3	66%
20	Эрүүл үрс сувилал	0	0
21	Хан туул сувилал	0	0
22	Бяцхан тэмүүлэл сувилал	1	100%
23	Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв	8	100%
24	Хонхор тосгоны Эрүүл мэндийн төв	14	100%

25	Туул тосгоны Эрүүл мэндийн төв	7	100%
----	--------------------------------	---	------

**Хоёр.** Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлын төрлөөр нь авч үзвэл:



**Гурав.** Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт



**Дөрөв.** Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа


Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл
	4	8	30	4833

**Тав.** Нийт 4833 ирсэн өргөдөл, гомдлын хандалтаас авч үзэхэд Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай гомдол нийт гомдлын 25 хувийг эзэлж байна.

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, гомдлын хувь
1	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай	1215	25.13
2	Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай	1198	24.7
3	Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай	1073	22.2
4	Яаралтай тусламж, үйлчилгээний тухай	528	10.9
5	Эрүүл мэндийн салбарын албан хаагчийн ёс зүй, утсан харилцааны тухай	254	5.2
	Нийгмийн халамж үйлчилгээ, тэтгэмжийн тухай	47	0.9
6	Цалин хөлсний тухай	46	0.95
7	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тухай	39	0.8
8	Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн тухай	28	0.5

9	Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны тухай	15	0.3
10	Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж, газрын тухай	13	0.2
10	Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны тухай	15	0.3
11	Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж техник хэрэгслийн тухай	47	0.9
	Бусад	315	6.5
	Нийт	<b>4833</b>	<b>100%</b>

**Зургаа.** Иргэдээс харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ирүүлсэн **2215** талархал байгаа нь ирсэн өргөдөл гомдлын 45.8 хувийг эзэлж байна.



**Долоо.** Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариу өгсөн хэлбэр

№	Хариу өгсөн хэлбэр	Тоо хэмжээ
1	Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн	<b>2256</b>
2	Програм хангамж + Мессежээр хариу өгсөн	<b>2160</b>
3	Програм хангамж + Мессеж + Албан бичгээр хариу өгсөн	<b>108</b>
4	Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн	<b>173</b>

Найм. Зөрчлийн үзүүлэлт.

Д/д	Ажил	Зөрчил	Тоо	Нийт
1	ХУДЭМТ	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	4	5
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	1	
2	СБДЭМТ	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	42	216
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	58	
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	115	
		Бусад	1	
3	СБДНЭ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	64	65
		Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй	1	
4	БЗДЭМТ	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй	1	1
5	Гачуурт -ТЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	3	3
6	Хонхор-ТЭМТ	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	1	9
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	7	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	1	
7	Багануур-ЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй, шилжүүлээгүй	2	2
8	Нийслэлийн түргэн тусламжийн төв-103	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	10	16
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	6	
9	Аддиктологийн төв	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	20	20
10	Налайх-ЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	1	1
11	БГДЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	99	111
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	5	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	7	
12	ЧДЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй, шилжүүлээгүй	83	109
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	5	
13	СХДЭМТ	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	6	10
		Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй	1	
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	3	
14	СХНЭ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	10	46
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	19	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	17	

15	ХУНЭ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	110	112
		Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй	2	
16	Багахангай-ЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	3	4
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	1	
17	Туул-ТЭМТ	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	2	8
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	1	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	5	
18	Энэрэл эмнэлэг	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	44	46
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	1	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	1	
19	Шүд эрүү нүүрний төв.	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	18	48
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	21	
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	9	
20	Жаргалант-ЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	2	2
<b>НИЙТ</b>			<b>450</b>	

Ес: Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 10 өргөдөл гомдол нь нийт 2045 гомдлын 0.4 хувийг эзэлж байна.

№	Байгууллага	Ажилтан	Төрөл	Бүртгэлийн дугаар	Хэтэрсэн хугацаа
1	СБДЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн алба-Х.Саранчимэг	Гомдол	G230805011	1.849
		Нийгмийн эрүүл мэндийн алба-Х.Саранчимэг	Хүсэлт	G230306101	0.937
		Эмнэлгийн тусламж үйлчилгээний алба-М.Одгэрэл	Гомдол	G2303030630	2.109
		Дотоод хяналт, шалгалтын алба Б.Гэрэлт-од	Гомдол	G230201053	5.915
		Эрүүл мэндийг дэмжих алба-Б.Хонгорзул	Гомдол	G230112071	2.089
		Мэс заслын клиник-У.Мягмарсүрэн	Гомдол	G221219002	1.253
2	СХНЭ	СХНЭ- Захиргаа-Б.Сүхтулга	Хүсэлт	O230706119	2.179
		СХНЭ- Захиргаа-Б.Сүхтулга	Хүсэлт	O230706117	2.153
		СХНЭ- Захиргаа-Б.Сүхтулга	Хүсэлт	O230706127	1.742

15	ХУНЭ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	110	112
		Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй	2	
16	Багахангай-ЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	3	4
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	1	
17	Туул-ТЭМТ	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	2	8
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	1	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	5	
18	Энэрэл эмнэлэг	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	44	46
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	1	
		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	1	
19	Шүд эрүү нүүрний төв.	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	18	48
		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	21	
		Явцын тэмдэглэл хөтлөөгүй	9	
20	Жаргалант-ЭМТ	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	2	2
<b>НИЙТ</b>			<b>450</b>	

Ес: Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 10 өргөдөл гомдол нь нийт 2045 гомдлын 0.4 хувийг эзэлж байна.

№	Байгууллага	Ажилтан	Төрөл	Бүртгэлийн дугаар	Хэтэрсэн хугацаа
1	СБДЭМТ	Нийгмийн эрүүл мэндийн алба-Х.Саранчимэг	Гомдол	G230805011	1.849
		Нийгмийн эрүүл мэндийн алба-Х.Саранчимэг	Хүсэлт	G230306101	0.937
		Эмнэлгийн тусламж үйлчилгээний алба-М.Одгэрэл	Гомдол	G2303030630	2.109
		Дотоод хяналт, шалгалтын алба Б.Гэрэлт-од	Гомдол	G230201053	5.915
		Эрүүл мэндийг дэмжих алба-Б.Хонгорзул	Гомдол	G230112071	2.089
		Мэс заслын клиник-У.Мягмарсүрэн	Гомдол	G221219002	1.253
2	СХНЭ	СХНЭ- Захиргаа-Б.Сүхтулга	Хүсэлт	O230706119	2.179
		СХНЭ- Захиргаа-Б.Сүхтулга	Хүсэлт	O230706117	2.153
		СХНЭ- Захиргаа-Б.Сүхтулга	Хүсэлт	O230706127	1.742

		СХНЭ- Захиргаа- Б.Сүхтулга	Хүсэлт	O230706121	1.742
		СХНЭ- Захиргаа- Б.Сүхтулга	Хүсэлт	O230706115	1.747
		СХНЭ- Захиргаа- Б.Сүхтулга	Хүсэлт	O230328141	0.052
3	НТТТөв-103	Захиргаа аж ахуй С.Акерке	Хүсэлт	O230904113	7.049
4	НШЭНТ	Захиргааны тасаг- Б.Батсайхан	Гомдол	G230619025	1.210
		Захиргааны тасаг- Д.Ханддорж	Гомдол	G221220056	3.867

**Харьяа эрүүл мэндийн байгууллагын өргөдөл гомдол шийдвэрлэхтэй холбоотойгоор хийж хэрэгжүүлсэн ажлын нийтлэг товч мэдээлэл:**

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гаргасан алдааг эмч нарт танилцуулан алдаа гаргасан тохиолдолд эмч сувилагч нарт хугацаатай үүрэг даалгавар өгч мэдлэг мэргэжлээ дээшлүүлэн, дахин гомдол саналгүй ажиллах арга хэмжээг авч ажилласан байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй гомдлыг байгууллагын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар, аюулгүй байдлын албанд шилжүүлдэг. Мөн бусад байгууллагаас албан тоот, тодорхойлолт шаардах, нэмэлт судалгаа, хийхээс бусад шалтгаантай өргөдлүүдийг ажлын 3 өдөрт багтаан хааж шийдвэрлэх чиглэлийг хэрэгжүүлж ажиллаж байна.

**Жишээ нь:** БЗДЭМТ –нь Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд залруулж болох санал гомдлыг тухай бүр шийдвэрлэх, иргэдэд мэдээ мэдээллийг хүртээмжтэй ойлгомжтой байдлаар хүргэх, харилцаа хандлагын асуудлыг анхаарч ажиллахыг чанар, эмнэлгийн тусламжийн албанаас тухай бүр зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллаж байна.

ӨЭМТ-үүдтэй өргөдөл гомдлыг бууруулах чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг хийж “Харилцаа хандлага” сайжруулах 1 сарын аянг 2-р улиралд зарлан хэрэгжүүлсэн. Аяны хүрээнд талархалын тоог нэмэгдүүлэх, гомдлын тоог тодорхой хувиар бууруулахаар ажиллаж байна. Цаашид талархалыг нэмэгдүүлж гомдлыг бууруулах зорилгоор өргөдөл гомдлын тодорхой хувийг эзэлж байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтны ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдлыг бууруулах чиглэлийг барьж Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн хороотой хамтарч 4,5 дүгээр сард харьяа салбар амбулатори, мэргэжилтнүүд, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн холбогдох эмч мэргэжилтнүүдэд Ёс зүйн сургалт хийж 205 эмч, эмнэлгийн ажилтанг хамруулсан.

“Эрүүл мэндийн байгууллагын ажилчдад тавигдах ёс суртахуун, соёлын шаардлага” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтыг явуулж, ЭМТ-ийн салбар амбулаториуд болон ӨЭМТ-дэд нэг нэг сургагч багш бэлдэж, бэлтгэгдсэн сургагч багш нараар салбарууд дээр нь сургалт оруулсан.

ЭМДҮЗ-ийн 08 дугаар тогтоол гарсантай холбоотой амбулаториудад болон ӨЭМТ-дэд 13а маягт илгээхтэй холбоотой гомдлууд нэмэгдсэн учир ЭМДЕГ-ын мэргэжилтнүүд болон харьяа НЭМГ, ЭМЯ-ны мэргэжилтнүүдтэй уулзаж гомдлыг бууруулах чиглэлээр тушаалын төсөлд саналаа өгсөн



Шинээр үүсгэн байгуулагдсан ӨЭМТ-дийн үйл ажиллагаатай танилцаж, чанарын багийн гишүүдтэй уулзалт хийн НЭМГ болон БЗДЭМТ-ийн даргын “Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” 2022 оны А/89 дугаар тушаалыг танилцуулж, гомдлыг хурдан шийдвэрлэх, аль болох гомдол гаргахгүй байх дээр анхаарч, хамтарч ажиллах чиглэл өгсөн.

ӨЭМТ-ийн дарга нартай уулзах уулзалтын үеэр гомдлын шийдвэрлэх хоногийг багасгах, бодитой шийдвэрлэх, ёс зүй, харьцаа хандлагатай холбоотой гомдол гаргахгүй байх талаар сануулж зөвлөлдсөн.

2023.11.03-ны өдөр нийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай хийсэн уулзалтаар өргөдөл гомдлыг бууруулахад анхаарах, шийдвэрлэх хугацаа богино байх, шийдвэрлэлтийг бодитой, иргэнд хүргэх хариу тодорхой, чанартай байх талаар зөвлөмж өгч, мэдээлэл танилцуулан 1 сарын аян зарлаж ажилласан.

**Дүгнэлт:** 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртлэх хугацаанд Харьяа 25 байгууллагын эрүүл мэндийн төвүүд болон нэгдсэн эмнэлгүүдийн тайлангаас шинжлэн судлахад: Эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагуудын эмчилгээ үйлчилгээ, ажлын хариуцлага, зохион байгуулалттай холбоотой, Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллага болон ӨЭМТ-н ачаалал их, үзлэгийн цаг авч чадахгүй байгаа, эмч нарын харилцаа, хандлага доголдолтой, эмч нарын хүрэлцээ муу, хүний нөөц дутуу, лавлах утас нь иргэдийн дуудлагыг хүлээн авдаггүй. Дүүрэг болон нэгдсэн эмнэлгийн эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой, Өрхийн эмнэлгүүдийн өдрийн эмчилгээний хуваарьт гомдолтой, амбулаторийн үзлэг буюу /ажилд орох/ эрүүл мэндийн үзлэгийн цагаан дэвтэр зуруулах 80,000 төгрөгийн төлбөртэй холбоотой гэх зэрэг агуулгаар нийт 4833 гомдол хүсэлт ирүүлсэн байна. Дээрх гомдлыг шийдвэрлэхэд дараах зөрчил, дутагдал байна. Үүнд:

1. Тулгамдсан асуудал буюу иргэн, үйлчлүүлэгчдээс ихэвчлэн ирүүлдэг гомдол, хүсэлт нь цаг олголтын 1800-0119- төвтэй ажиллах хоорондын уялдаа холбоог сайжруулах, ажиллах чиглэлийг илүү тодорхой болгох.

2. Хувийн эмнэлгүүд ӨЭМТ-ээс 13А маягт авч ирсэн тохиолдолд хөнгөлөлт үзүүлнэ гэсэн асуудлаас үүдэлтэйгээр ЭМТ-ийн болон ӨЭМТ-н ачаалал ихссэн.

**(Энэ асуудал 2023 оны 3-р улиралд шийдэгдсэн ч өмнөх улирлын гомдлын ихэнх хувийг эзэлж байна.)**

3. 1800-0119 дугаараас үзлэгийн цаг олгохдоо даатгалыг бүрэн шалгаагүйгээс асуудал үүсэж байна. Дүүргийн цахим бүртгэлээс эмчийн үзлэгийн цагийг шалгахад сул цаг байгаа хэдий ч 1800-0119 дугаарын утаснаас цаг авах гэхэд нь байхгүй гэсэн шалтгаанаар иргэдэд цагийг ойрын хугацаанд олгохгүй хүлээгдсэн, чирэгдэл учруулж бухимдал үүсгэдэг нь дүүргийн цахим бүртгэлийн ачааллыг нэмэгдүүлж байна.

4. Байгууллагын дотоод журам, цаг ашиглалт, үйлчилгээний соёл, ээлжийн амралттай болон төлөвлөгөөт ажилтай эмчийн цагийг урьдчилан хаасан ч программын шинэчлэл өөрчлөлттэй холбоотой үзлэгийн цагийг автоматаар нээгдсэн, тухайн төвөөс цаг олгогдож байхгүй эмч дээр үзүүлэхээр иргэд ирж өөр эмчид чирэгдэл үүсгэх тохиолдол гардаг.

5. Төлбөртэй тусламж үйлчилгээний журамтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх үзлэгийн үнийн дүн ихэссэн нь мөн гомдол гарах шалтгаан болж байна.



6. Хүний нөөцийн дутагдалтай байгаа нь байгууллагын сул орон тооны зарыг тогтмол байршуулсан ч ажилд орох сонирхолтой эмч, ажилчид ирэхгүй, шаардлага хангахгүй зэрэг асуудал, жирэмсний урт хугацааны амралт зэрэг нь зарим үзлэгийн кабинетын ачаалал ихсэж иргэд болон эмнэлгийн ажилчдад бухимдал үүсгэж байна.

7. Эрт илрүүлгийн үзлэг оношлогооны асуудал, эмчийн орон тооны асуудал, мөн хувийн хэвшлийн гэрээт зарим эмнэлгийн үйлчилгээний чанар муу, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээлэл дутмаг байгаагаас гомдол гарч байна.

**Цаашид:**

1. Иргэд рүү чиглэсэн сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, хууль дүрмийн мэдлэг тал дээр анхаарах.

2. ЭМЯ, НЭМГ-аас гарч буй шийдвэр, журмыг шуурхай мэдээлэх, зохион байгуулж буй хөтөлбөрүүд болон үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд үнэн зөв түгээж байх.

3. Ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн ажиллах, ёс зүй харьцаа хандлагын чиглэлээр сургалтуудыг нэмэгдүүлэх.

4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахаар ирсэн үйлчлүүлэгчдийг түргэн шуурхай, чирэгдэлгүй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажиллах,

5. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан алдааг эмч нарт танилцуулан, тохиолдол гаргасан эмч,сувилагч нарт хугацаат үүрэг даалгавар өгч, мэдлэг мэргэжлдээ дээшлүүлэх, дахин гомдол санал гаргахгүй байх тал дээр аргазүйн зөвөлгөө өгөх

6. Эмч, сувилагч болон ажилтнууд олон ажил хавсран хийх нь ажлын гүйцэтгэл, бүтээмжид сөргөөр нөлөөлж буй эрсдлийг арилгах

7.Өргөдөл гомдол гаргасан үйлчлүүлэгчтэй биечлэн уулзах, эмнэлгийн дотоод журам болон ЭМЯ, НЭМГ-аас гаргасан журам заавар, бусад хууль тогтоомжийг зөв тайлбарлаж ойлгуулах

ЗӨВШӨӨРСӨН: ДАРГА ..... П.ЭРХЭМБУЛГАН

ХЯНАСАН: ЗТУХ-ИЙН ДАРГА ..... Ш.УРАНЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН: МЭРГЭЖИЛТЭН ..... Д.НАРАНТУУЛ

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

**2023 он**